

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэнгийн 2023 оны  
санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/433/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Улаанбаатар хот

2024 он

Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,  
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naramchimegts@audit.gov.mn](mailto:naramchimegts@audit.gov.mn)  
Аудитын менежер: Б.Лхагвацэнд  
Утас: 261885 Цахим хаяг: [lkhagvatsendb@audit.gov.mn](mailto:lkhagvatsendb@audit.gov.mn)  
Аудитор: П.Цогзолмаа  
Утас: 261885 Цахим хаяг: [tsogzolmaap@audit.gov.mn](mailto:tsogzolmaap@audit.gov.mn)  
Мишээл-Од Аудит ХХК-ийн захирал: Т.Одончимэг  
Утас: 70169029 Цахим хаяг: [info@misheelodaudit.mn](mailto:info@misheelodaudit.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ДУЛААНЫ ТЕХНИК, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН  
ЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН  
ЗАХИРАЛ Д.ЭНХЖАРГАЛ ТАНАА

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2024.02.23 № 07/350  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэнгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэнгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар 77,926.4 мянган төгрөгийн цалингийн зардлыг хэтрүүлэн зарцуулсан, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 49 нэр төрлийн 585,943.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох тухай өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зэрэг нийт 836,906.8 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон 14,015.3 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давсан, Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Асуудлыг онцолсон хэсэг

Засгийн газрын “Шинжлэх ухаан, технологийн салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2021 оны 299 дүгээр тогтоолын 7, 2019 оны 328 дугаар тогтоолын 1.1-д “Шинжлэх ухаан, технологийн салбарын санхүүжилтийг төлөвлөлтийн дагуу жил

бүрийн улсын төсөвт тусгах"-аар заасны дагуу 2022 оноос эхлэн төсөвт байгууллага болон зохион байгуулагдаж 2023 онд улсын төсвийн санхүүжилтээр 934,353.0 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтээр 184,742.5 мянган төгрөгийг төвлөрүүлэн ажилласан байна.

### **Аудитын гол асуудал**

Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн улсын төсөвт шилжиж, 12 орон тоог нэмэгдүүлэн 48 хүнээр баталж, төсөв нэмэгдсэн ч тайлант онд гүйцэтгэсэн ажлын тайлангаар ажлын гүйцэтгэл хангалтгүй, төсвийг үндэслэлтэй, үр ашигтай төлөвлөөгүй, өрсөлдөх чадвартай мэргэжилтэн, судлаачдыг бэлтгэх, инновацид суурилсан шинжлэх ухаан, технологийг нэвтрүүлэх, хатуу хаягдлыг боловсруулан ашиглах үйлдвэрийн үнэлгээ хийх, эрдэм шинжилгээний туршилт судалгаа хийх зорилгуудаа бүрэн хангаж ажиллаагүй байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл үндсэн үйл ажиллагааны 1 хөтөлбөрийн хүрээнд 717,246.6 мянган төгрөг буюу 76.8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 217,106.4 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>317,139,403.99</b>	<b>40,583,984.14</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>137,103.99</b>	<b>190,189.14</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	137,103.99	190,189.14
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>317,002,300.00</b>	<b>16,200,000.00</b>
34600	Урьдчилж гарсан зардал	317,002,300.00	16,200,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>-</b>	<b>24,193,795.00</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>-</b>	<b>24,193,795.00</b>
35410	Бичиг хэргийн материал	-	514,600.00
35420	Аж ахуйн материал	-	19,800.00
35470	Бусад хангамжийн материал	-	23,659,395.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,069,470,930.24</b>	<b>1,013,112,918.84</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,069,470,930.24</b>	<b>1,013,112,918.84</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,015,319,930.24</b>	<b>959,261,918.84</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	679,035,860.00	679,035,860.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(122,872,753.69)	(144,147,765.61)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,442,226,499.29	1,512,969,589.29
39206	Хуримтлагдсан элэгдэл	(989,874,308.90)	(1,098,244,461.50)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	14,600,000.00	19,557,800.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(14,244,366.76)	(16,258,103.68)
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,000,000.00	3,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(779,999.70)	(879,999.66)
39217	Ном	4,229,000.00	4,229,000.00
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>54,151,000.00</b>	<b>53,851,000.00</b>
39301	Програм хангамж	2,080,000.00	2,080,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,180,000.00)	(1,480,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	53,251,000.00	53,251,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,386,610,334.23</b>	<b>1,053,696,902.98</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,386,610,334.23</b>	<b>1,053,696,902.98</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,386,610,334.23</b>	<b>1,053,696,902.98</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	319,956,570.00	-
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	319,956,570.00	-
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	-	319,956,570.00
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>631,971,352.51</b>	<b>299,057,921.26</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	654,059,418.50	318,728,990.51
51220	Тайлант үеийн үр дүн	(22,088,065.99)	(19,671,069.25)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	434,682,411.72	434,682,411.72
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,386,610,334.23</b>	<b>1,053,696,902.98</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>818,209,705.15</b>	<b>1,179,727,357.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>58,194,700.00</b>	<b>60,631,810.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>58,194,700.00</b>	<b>60,631,810.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>50,200,000.00</b>	<b>-</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	50,200,000.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	7,994,700.00	42,656,490.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	17,975,320.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>760,015,005.15</b>	<b>1,119,095,547.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>568,165,500.00</b>	<b>934,353,000.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	568,165,500.00	934,353,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>191,849,505.15</b>	<b>184,742,547.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,500,000.00	24,286,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	174,349,505.15	160,455,747.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>840,297,771.14</b>	<b>1,199,398,426.25</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>840,297,771.14</b>	<b>1,199,398,426.25</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>817,603,113.71</b>	<b>970,586,403.21</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>378,935,385.21</b>	<b>568,086,584.16</b>
210101	Үндсэн цалин	296,848,038.18	389,115,664.95
210102	Нэмэгдэл	45,786,950.84	66,938,688.81
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,026,499.85	62,671,909.00
210104	Урамшуулал	9,273,896.34	49,360,321.40
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>44,813,534.57</b>	<b>64,610,301.86</b>
210201	Тэтгэврийн даатгал	34,157,994.79	48,404,181.94
210202	Тэтгэмжийн даатгал	3,774,845.22	5,675,405.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,996,356.13	4,509,525.69
210204	Ажилгүйдлийн даатгал	546,120.12	445,835.30
210205	Эрүүл мэндийн даатгал	3,338,218.31	5,575,353.61
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>54,309,302.73</b>	<b>50,958,950.48</b>
210301	Гэрэл, цахилгаан	53,979,102.73	50,958,950.48
210302	Түлш, халаалт	330,200.00	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>21,365,566.15</b>	<b>14,489,775.09</b>

210401	Бичиг хэрэг	3,637,536.15	1,059,650.00
210402	Тээвэр, шатахуун	5,666,630.00	1,885,440.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,609,000.00	3,025,745.09
210404	Ном, хэвлэл	1,400,000.00	640,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,539,000.00	993,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,513,400.00	6,885,940.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>6,650,000.00</b>	<b>3,676,880.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,302,000.00	1,384,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,348,000.00	2,292,180.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>68,316,229.00</b>	<b>5,745,550.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	429,229.00	-
210604	Урсгал засвар	67,887,000.00	5,745,550.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,904,215.00</b>	<b>2,912,300.00</b>
210702	Дотоод албан томилолт	4,904,215.00	2,472,300.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	440,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>81,956,475.12</b>	<b>120,678,772.22</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	78,795,039.12	118,335,530.22
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,101,000.00	2,000,000.00
210807	Газрын төлбөр	1,039,586.00	343,242.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	20,850.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>156,352,405.93</b>	<b>139,427,289.40</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,315,490.00	6,726,180.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	2,360,070.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	122,036,915.93	130,341,039.40
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>22,694,657.43</b>	<b>228,812,023.04</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>500,000.00</b>	<b>-</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	-
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>22,194,657.43</b>	<b>228,812,023.04</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,967,794.28	217,106,411.26
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	226,863.15	11,705,611.78
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>(22,088,065.99)</b>	<b>(19,671,069.25)</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>(22,088,065.99)</b>	<b>(19,671,069.25)</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>810,357,481.59</b>	<b>1,119,095,547.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>50,342,476.44</b>	-
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>50,342,476.44</b>	-
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>50,342,476.44</b>	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	50,342,476.44	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>760,015,005.15</b>	<b>1,119,095,547.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>568,165,500.00</b>	<b>934,353,000.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	568,165,500.00	934,353,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>191,849,505.15</b>	<b>184,742,547.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,500,000.00	24,286,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	174,349,505.15	160,455,747.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>765,111,410.59</b>	<b>1,091,528,947.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>765,111,410.59</b>	<b>1,091,528,947.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>742,416,753.16</b>	<b>862,716,923.96</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>405,014,268.82</b>	<b>568,086,584.16</b>
210101	Үндсэн цалин	322,926,920.79	389,115,664.95
210102	Нэмэгдэл	45,786,950.84	66,938,688.81
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,026,499.85	62,671,909.00
210104	Урамшуулал	9,273,897.34	49,360,321.40
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>76,196,340.34</b>	<b>64,663,387.01</b>
210201	Тэтгэврийн даатгал	65,540,800.18	48,457,267.09
210202	Тэтгэмжийн даатгал	3,774,845.22	5,675,405.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,996,356.13	4,509,525.69
210204	Ажилгүйдлийн даатгал	546,120.12	445,835.30
210205	Эрүүл мэндийн даатгал	3,338,218.69	5,575,353.61
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>54,309,302.73</b>	<b>50,958,950.48</b>
210301	Гэрэл, цахилгаан	53,979,102.73	50,958,950.48
210302	Түлш, халаалт	330,200.00	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>22,179,766.15</b>	<b>18,681,350.09</b>
210401	Бичиг хэрэг	3,589,536.15	1,516,450.00
210402	Тээвэр, шатахуун	3,854,700.00	1,885,440.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,609,000.00	3,025,745.09
210404	Ном, хэвлэл	1,400,000.00	640,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,539,000.00	993,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,187,530.00	10,620,715.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>6,650,000.00</b>	<b>3,676,880.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,302,000.00	1,384,700.00

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,348,000.00	2,292,180.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>61,709,019.00</b>	<b>11,205,150.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	429,229.00	259,600.00
210604	Урсгал засвар	61,279,790.00	10,945,550.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>6,716,145.00</b>	<b>2,912,300.00</b>
210702	Дотоод албан томилолт	6,716,145.00	2,472,300.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	440,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>94,181,011.12</b>	<b>131,678,772.22</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	91,019,575.12	129,335,530.22
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,101,000.00	2,000,000.00
210807	Газрын төлбөр	1,039,586.00	343,242.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	20,850.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>15,460,900.00</b>	<b>10,853,550.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,460,900.00	8,493,480.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	2,360,070.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>22,694,657.43</b>	<b>228,812,023.04</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>500,000.00</b>	<b>-</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	-
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>22,194,657.43</b>	<b>228,812,023.04</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,967,794.28	217,106,411.26
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	226,863.15	11,705,611.78
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>45,246,071.00</b>	<b>27,566,600.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>45,246,071.00</b>	<b>27,566,600.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>45,246,071.00</b>	<b>27,566,600.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>45,246,071.00</b>	<b>27,566,600.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	45,246,071.00	27,566,600.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(45,246,071.00)</b>	<b>(27,566,600.00)</b>

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**  
 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>319,956,570.00</b>	<b>434,682,411.72</b>	<b>654,059,418.50</b>	<b>1,408,698,400.22</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>319,956,570.00</b>	<b>434,682,411.72</b>	<b>654,059,418.50</b>	<b>1,408,698,400.22</b>
4	Тайлант үеийн үр дүн	-	-	(22,088,065.99)	(22,088,065.99)
5	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>319,956,570.00</b>	<b>434,682,411.72</b>	<b>631,971,352.51</b>	<b>1,386,610,334.23</b>
6	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(313,242,362.00)	(313,242,362.00)
7	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>319,956,570.00</b>	<b>434,682,411.72</b>	<b>318,728,990.51</b>	<b>1,073,367,972.23</b>
8	Тайлант үеийн үр дүн	-	-	(19,671,069.25)	(19,671,069.25)
9	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>319,956,570.00</b>	<b>434,682,411.72</b>	<b>299,057,921.26</b>	<b>1,053,696,902.98</b>

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>934,353,000.00</b>	<b>717,246,588.74</b>	<b>217,106,411.26</b>	<b>76.7</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>934,353,000.00</b>	<b>717,246,588.74</b>	<b>217,106,411.26</b>	<b>76.7</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>748,510,600.00</b>	<b>565,986,584.16</b>	<b>182,524,015.84</b>	<b>75.6</b>
210101	Үндсэн цалин	485,879,300.00	387,015,664.95	98,863,635.05	79.6
210102	Нэмэгдэл	128,369,700.00	66,938,688.81	61,431,011.19	52.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	68,112,000.00	62,671,909.00	5,440,091.00	92.0
210104	Урамшуулал	66,149,600.00	49,360,321.40	16,789,278.60	74.6
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>93,563,800.00</b>	<b>64,447,087.01</b>	<b>29,116,712.99</b>	<b>68.9</b>
210201	Тэтгэврийн даатгал	63,623,400.00	48,240,967.09	15,382,432.91	75.8
210202	Тэтгэмжийн даатгал	7,485,100.00	5,675,405.32	1,809,694.68	75.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,988,100.00	4,509,525.69	1,478,574.31	75.3
210204	Ажилгүйдлийн даатгал	1,497,000.00	445,835.30	1,051,164.70	29.8
210205	Эрүүл мэндийн даатгал	14,970,200.00	5,575,353.61	9,394,846.39	37.2
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>51,007,800.00</b>	<b>50,958,950.48</b>	<b>48,849.52</b>	<b>99.9</b>
210301	Гэрэл, цахилгаан	51,007,800.00	50,958,950.48	48,849.52	99.9
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>10,253,500.00</b>	<b>9,076,575.09</b>	<b>1,176,924.91</b>	<b>88.5</b>
210401	Бичиг хэрэг	1,709,200.00	1,516,450.00	192,750.00	88.7
210402	Тээвэр, шатахуун	1,889,100.00	1,885,440.00	3,660.00	99.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,392,400.00	3,025,745.09	366,654.91	89.2
210404	Ном, хэвлэл	947,100.00	640,000.00	307,100.00	67.6
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,734,600.00	993,000.00	741,600.00	57.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	581,100.00	1,015,940.00	(434,840.00)	174.8
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>3,515,700.00</b>	<b>2,972,000.00</b>	<b>543,700.00</b>	<b>84.5</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,384,700.00	1,384,700.00	-	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,131,000.00	1,587,300.00	543,700.00	74.5
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,745,800.00</b>	<b>5,745,550.00</b>	<b>250.00</b>	<b>100.0</b>
210604	Урсгал засвар	5,745,800.00	5,745,550.00	250.00	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,356,800.00</b>	<b>1,702,300.00</b>	<b>654,500.00</b>	<b>72.2</b>
210702	Дотоод албан томилолт	1,788,600.00	1,262,300.00	526,300.00	70.6
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	568,200.00	440,000.00	128,200.00	77.4
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>11,689,600.00</b>	<b>8,890,742.00</b>	<b>2,798,858.00</b>	<b>76.1</b>

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,815,500.00	6,547,500.00	1,268,000.00	83.8
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00	-	100.0
210807	Газрын төлбөр	1,441,600.00	343,242.00	1,098,358.00	23.8
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	432,500.00	-	432,500.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>7,709,400.00</b>	<b>7,466,800.00</b>	<b>242,600.00</b>	<b>96.8</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,709,400.00	7,466,800.00	242,600.00	96.8
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>934,353,000.00</b>	<b>717,246,588.74</b>	<b>(217,106,411.26)</b>	<b>76.8</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>934,353,000.00</b>	<b>717,246,588.74</b>	<b>(217,106,411.26)</b>	<b>76.8</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	934,353,000.00	717,246,588.74	(217,106,411.26)	76.8
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>48</b>	<b>33</b>	<b>15</b>	<b>68.7</b>
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	42	27	15	64.3
620003	Үйлчлэх ажилтан	5	5	-	100.0

**2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>184,742,547.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>184,742,547.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>173,036,935.22</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		<b>2,100,000.00</b>
210101	Үндсэн цалин		2,100,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		<b>216,300.00</b>
210201	Тэтгэврийн даатгал		216,300.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		<b>11,404,775.00</b>
210404	Ном, хэвлэл		1,800,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		9,604,775.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>		<b>704,880.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		704,880.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		<b>30,641,300.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл		24,191,300.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		1,250,000.00
210604	Урсгал засвар		5,200,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>		<b>1,210,000.00</b>
210702	Дотоод албан томилолт		1,210,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		<b>122,788,030.22</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		122,788,030.22
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		<b>3,971,650.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		1,611,580.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		2,360,070.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>11,705,611.78</b>
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		<b>11,705,611.78</b>
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		11,705,611.78
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>184,742,547.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		<b>184,742,547.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		24,286,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		160,455,747.00
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		<b>0.00</b>
<b>11000</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>0.00</b>
<b>12000</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>0.00</b>

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 574.4 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 553.8 сая төгрөгийн 3 алдааг залруулж, 20.6 сая төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн дүн нь 217,106.4 мянган төгрөгөөр илүү тусгасан	1	217,106.4			1	217,106.4	1	217,106.4				
2016-2017 онуудад гэрээ байгуулж 2018-2019 онуудад гүйцэтгэж дууссан 4 төсөл арга хэмжээний 317,002.3 мянган төгрөгийн зардлын тухайн тайлант онуудад зардлаар хүлээн зөвшөөрөөгүй урьдчилж төлсөн зардал дансанд хуримтлуулан бүртгэсэн	1	317,002.3			1	317,002.3	1	317,002.3				
Цалингийн зардлын дүн санхүүгийн үр дүнгийн тайланд 2,295.8 мянган төгрөгөөр, цалин хөдөлмөрийн хөлс тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан орлогын албан татварын тайланд 17,404.8 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй илэрхийлэгдсэн	1	19,700.6			1	19,700.6	1	19,700.6				
Тайлант жилийн элэгдлийн зардлыг хянахад 9 нэр төрлийн 13,538.4 мянган	1	18,246.3			1	18,246.3			1	18,246.3	1	18,246.3

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

төгрөгийн анхны өртөгтэй хөрөнгө нь ашиглалтын хугацаанаас өмнө элэгдүүлж дуусгасан ба 4,707.9 мянган төгрөгийн анхны өртөгтэй хөрөнгөд тайлант хугацаанд элэгдэл байгуулаагүй байна.												
Татварын цахим системд Цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татварын өглөг 2,201.6 мянган төгрөгөөр тусгагдсан байхад санхүүгийн тайланд өрийн үлдэгдэлгүй буюу зөрүүтэй тайлагнагдсан. Мөн НДШ-ийн авлага санхүүгийн тайланд 137.1 мянган төгрөгөөр илүү тайлагнагдсан байна.	1	2,338.7			1	2,338.7			1	2,338.7	1	2,338.7
Дүн	5	574,394.3	0	0.0	5	574,394.3	3	553,809.3	2	20,585.0	2	20,585.0

Аудитаар нийт 836.9 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 173.0 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 663.9 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Өмнөх аудитаар илэрсэн "Тайлант хугацааны эцэст ашиглалтад байгаа үлдэх өртөггүй 456,589.4 мянган төгрөгийн анхны өртөг бүхий биет болон биет бус хөрөнгийн үнэ цэнийг тодорхойлоогүй, бодит үнэ цэнээр илэрхийлээгүй байна." гэсэн алдаанд зөвлөмж өгсөн боловч хэрэгжүүлээгүй буюу тайлант оны байдлаар элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн нийт 49 нэр төрлийн 585,943.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй ба үнийг шинэчлэн тогтоогоогүй байна.	1	585,943.5					1	585,943.5				
Нэмэлт санхүүжилтийн дансанд 5 төсөл арга хэмжээний 154,791.4 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 173,036.9 мянган төгрөгийн зарцуулалт хийсэн байна. Эдгээр 5 төсөл арга хэмжээг гүйцэтгэхдээ гадны байгууллагуудтай гэрээ байгуулан гүйцэтгүүлж, хэмнэлт гаргаагүй байна	1	173,036.9			1	173,036.9						

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн улсын төсөвт шилжиж, 12 орон тоог нэмэгдүүлэн 48 хүнээр батлаж, төсөв нэмэгдсэн ч тайлант онд гүйцэтгэсэн ажлын тайлангаар ажлын гүйцэтгэл хангалтгүй, 2022 онд тайлагнасан ажлыг 2023 онд дахин хийснээр давхардуулан тайлагнасан, төсвийг үндэслэлтэй, үр ашигтай төлөвлөөгүй, 25 эрдэм шинжилгээний ажилтан ажиллаж цалин авч байгаа боловч 15 ажилтныг эрдэм шинжилгээний ажилтан гэх нотлох баримтгүй, нийт ажиллагсдын 51.5 % нь өндөр насны тэтгэвэртэй иргэдийг цалинжуулдаг ба өрсөлдөх чадвартай мэргэжилтэн, судлаачдыг бэлтгэх, инновацид суурилсан шинжлэх ухаан, технологийг нэвтрүүлэх, хатуу хаягдлыг боловсруулан ашиглах үйлдвэрийн үнэлгээ хийх, эрдэм шинжилгээний туршилт судалгаа хийх зорилгуудаа бүрэн хангаж ажиллаагүй байна.	1				1							
Тайлант онд 626,548.4 мянган төгрөгийн үндсэн болон нэмэгдэл цалин олгохоор тооцоолсон байтал төсөв батлахдаа 748,510.6 мянган төгрөгөөр баталснаас 121,962.2 мянган төгрөгийн цалин илүү баталж, төсвийг үндэслэлгүй баталсан. Мөн тайлант хугацаанд 12 ажилтан ажиллаагүйгээс 138,488.2 мянган төгрөгийн цалин хэмнэгдэх боломжтой зэргээс цалингийн хэмнэлт 260,450.4 мянган төгрөг гарах байтал 182,524.0 мянган төгрөгийн зардал хэмнэгдэж 77,926.4 мянган төгрөгийн цалингийн зардлыг хэтрүүлсэн байна.	1	77,926.4				1	77,926.4					
Дүн	4	836,906.8	0	0.0	2	173,036.9	2	663,869.9	0	0.0	0	0.0

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 805.6 сая төгрөгийн зөрчил илэрснээс 533.4 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 272.2 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Тайлант хугацаанд оруулбал зохих 171 мэдээллээс 165 мэдээллийг хугацаанд нь оруулсан ба хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 3 мэдээлэл байна. Мөн Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 5 удаагийн 279,623.2 мянган төгрөгийн орлого, 5 удаагийн 253,789.8 мянган төгрөгийн зарлагын мөнгөн гүйлгээг шилэн дансанд хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	533,413.0	1	533,413.0		
Дүн	1	533,413.0	1	533,413.0		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Тайлант онд 249,146.0 мянган төгрөгийн 8 удаагийн ажил үйлчилгээ худалдан авах, 1 удаагийн 23,026.0 мянган төгрөгийн бараа худалдан авах гэрээг тус тус байгуулсан байна. Эдгээр худалдан авалттай холбоотой тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулаагүй, тайлан бэлтгээгүй байна.	1	272,172.0			1	272,172.0
Дүн	1	272,172.0			1	272,172.0
Нийт дүн	2	805,585.0	1	533,413.0	1	272,172.0